

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2009 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ /Сүхбаатар аймаг/**

2009 оны 12 сарын 31-ний ба

№	Зорилт, арга хэмжээ	Хэмжих нэгж, шалгуур үзүүлэлт	2009 онд хүрэх түвшин	Хариуцан хэрэгжүүлэх Засгийн газрын гишүүн, албан тушаалтан	Биелэлт
1	5.3. Өрхийн аж ахуйгаас бэлтгэсэн илүүдэл төмс, хүнсний ногоо, мах, сүү, цагаан идээ борлуулах, татвар, түрээсийн төлбөргүй хүнсний зах, салбар, цэгүүдийг аймаг, сумын төв, нийслэлийн дүүрэг, хороодод байгуулж ажиллуулах	хүнсний зах, цэгүүд ажиллаж эхлэх	-	Т.Бадамжунай, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар	"Сүхбаатар хөгжил-2009" зах зээлийн өдөрлөгийг 9 дүгээр сард амжилттай зохион байгуулсан. Өдөрлөгийн арга хэмжээнд нийт 190 аж ахуй нэгж, үйлдвэрлэл эрхлэгчид, малчны бүлэг оролцон, 84.4 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Аймгийн төвд хүнсний 2 зах ажиллаж байна.
2	5.4. Нийслэл болон орон нутгийн томоохон хотуудад экологийн цэвэр сүү, цагаан идээ, мал болон гахай, тахианы мах, махан бүтээгдэхүүн, өндөгний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж, "Сүү" хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх	-	-	Т.Бадамжунай, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар	2009 онд "Сүү" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөв олон нийтэд сурталчлах, сургалт явуулах, сүү, цагаан идээний үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, сүү, сүүн бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор аж ахуйн нэгж, иргэдийг төсөл хөтөлбөрт хамруулах, жижиг сүүний чиглэлийн үнээний фермийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, сүүн бүтээгдэхүүний чанар, стандартад хяналт шалгалт хийх зэрэг
3	11.5. Газрын нэгдсэн төлөвлөгөөг Улсын Их Хурлаар батлуулж, нийслэл, аймгуудын төв болон төвлөрсөн суурингийн гэр хорооллыг барилгажуулахаас бусад газруудыг зөвхөн нээлттэй дуудлага худалдаагаар худалдах тогтолцоонд шилжих	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Х.Баттулга, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар	Аймгийн ИТХ-ын 2008 оны хуралдаанаар "2009 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-өөр аймгийн хэмжээнд эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалтыг баталсан бөгөөд Газрын тухай хууль, газрын дуудлага худалдаа явуулах журмын дагуу аймгийн төв Баруун Урт сумын инженерийн шугам сүлжээ бүхий 1500 м2 2 газар дээр нээлттэй дуудлага худалдаа зохион байгууллаа. Уг дуудлага худалдааны анхы үнийг 900.0 мянган төгрөгөөс дуудан нөгийг нь 1600.0 мянган төгрөг, нөгөөг нь 4700.0 мянган төгрөгөөр худалдан борлууллаа.
4	11.7. Говь, хээр, цөлжилт ихээр явагдаж байгаа бүс нутгуудад усны нөөцийг нэмэгдүүлэх, мод, бут сөөг тарьж ургуулах ажлыг эрчимжүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Л.Гансүх, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар	2009 онд Аймгийн Засаг дарга, БОАЖСайдын хооронд бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний дагуу Баяндэлгэр сумын Өлзийт булаг, Наран сумын Хашаатын булаг, Дарьганга сумын Хамар булаг, Сүхбаатар сумын Яргайтын булаг, Эрдэнэцагаан сумын Цайдам зэрэг 5 булгийн эхийг, "Цөлжилтийг бууруулах газрын тогтвортой менежмент" төслийн санхүүжилтээр Баяндэлгэр сумын Дэрсэнд шанд, Дэлгэрийн худгийг түшиглүүлэн нийт 4.5 га, Уулбаян сумын зүүн булаг, Дөш, Жаргалантын булгуудын эхийн 7 га газрыг бүрэн хашаажуулж, 6000 орчим мод суулгацыг тариад байгаагийн дээр Асгат, Дарьганга, Наран, Сүхбаатар, Түмэнцогт, Түвширширээ, Эрдэнэцагаан сумд өөрийн хөрөнгө хүчээр 9 булаг, нийтдээ 18 булгийг тохижуулаад байна.
5	11.7.1. Говь хээрийн бүсэд усан сан, хөв байгуулах, мод бут сөөг тарьж ургуулах ажлын үр дүнг сайжруулан арчилгаа, хамгаалалтыг сайжруулах	-	-	Л.Гансүх, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар	2009 онд төсвийн хөрөнгөөр Дарьганга сум элсний нүүлтээс хамгаалахад 3500 ширхэг тарьц, суулгац тарьсны дээр дэрс шилжүүлэн 2 га газарт суулгасан. Мөн Онгон сум 1 га газарт 1200 ширхэг чацаргана, төвдөө 200-аад суулгац тарьсны дээр бусад сумдууд тус бүр 100-800 ширхэг мод суулгацыг тарьж газрын доройтлоос сэргийлэх арга хэмжээг авч байна.

6	11.8. Говь, хээрийн цөлжилт ихээр явагдаж байгаа бүсүүдэд баянбүрд үүсгэх, худаг ус гаргах, усжуулах бүхий л санал, санаачилгыг дэмжиж, "Ус" хөтөлбөрийг үргэжлүүлэн хэрэгжүүлэх, хөдөөгийн баг бүрт сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглан шинээр 1 худаг нэмж гаргах ажлыг эхлүүлэх	-	-	Л.Гансүх, Т.Бадамжунай, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар	Цөлжилт нь тус аймгийн Дарьганга, Онгон, Баяндэлгэр, Уулбаян, Түвшинширээ сумдад хүчтэй явагдаж нийт нутгийн 50-70 хувь нь цөлжсөн байна. Уг сумдын цөлжилтийг бууруулах зорилгоор аймгийн ИТХ-аас Цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Улсын төсвийн хөрөнгөөр гаргах инженерийн хийцтэй худгийн захиалгыг орон нутгийн багийн иргэдийн санал санаачлагыг үндэслэн төлөвлөж энэ онд бүх сумдад нийтдээ 24 инженерийн хийцтэй худаг, сум орон нутаг өөрсдийн хөрөнгө хүчээр 88 гар худгийг гаргаснаар 120 000 га газар усжуулагдаж, 100 гаруй мянган толгой мал сүргийг усаар хангах боломж бүрдсэн. Мөн Онгон сумын Хавиргын булгийн 18 га-ийн хуучин услалтын системийг сэргээн засварлах ажлыг улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийж, ашиглалтанд хүлээн авлаа.
7	14.16.1. Орон нутгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн тусгай зөвшөөрлийн шаардлагыг хэрхэн хангаж буйг судлан дүгнэлт гаргаж, орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлэх аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Төрийн өмчийн хорооны шийдвэр болон Засгийн газрын шийдвэр гаргах санал боловсруулах	-	-	Ё.Отгонбаяр, Аймгийн Засаг дарга нар	Тус аймагт орон нутгийн өмчийн МСУ төв байхгүй, ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль болох Технологийн сургуультай. Энэ сургуульд мэргэжлийн анхан шатны боловсрол олгох сургалт явуулдаг салбартай болсноос хойш энэ хичээлийн жилд 3 дахь төгсөлтөөр 5 мэргэжлээр 92 хүүхдийг төгсгөж, мэргэжлийн үнэмлэх гардуулан, мэргэжилтэй ажилчны эгнээнд шилжүүлээ.
8	15.13. Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах зорилгоор бүсийн болон аймаг, нийслэлд шүдний кабинет байгуулах ажлыг дэмжиж, хэрэгжүүлэх	байгуулах шүдний кабинетийн тоо	16	С.Ламбаа, Аймаг, нийслэлийн Засаг дарга	ХБНГУ-ын Нюрнберг хотын "Зах хязгааргүй шүдний эмч нар" байгууллагаас АНЭ, Онгон сумын сум дундын эмнэлэгт хүүхдийн шүдний кабинет байгуулан шүдний эмнэлгийн зориулалттай иж бүрэн зөөврийн аппарат суурилуулж амны хөндийн үзлэгт 16096 хүнийг хамруулснаас 10978 буюу 68.2 хувь нь шүд цоорох өвчтэй байсан ба 136-г нь хяналтанд авч эрүүлжүүлээ.
9	15.17. Нийтийн биеийн тамир, спортын материаллаг баазыг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх, нийтийн биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлогыг батлуулж, хэрэгжүүлж эхлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	С.Ламбаа, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар	"Нийтийн биеийн тамирын талаар баримтлах бодлого"-г боловсруулахтай холбогдуулан түүнд тусгуулах саналаа холбогдох газруудад хүргүүлэв. Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд нийтийн биеийн тамирын арга хэмжээг 34 удаа зохион байгуулж 3526 хүнийг хамруулсан нь өмнөх оноос 38% өссөн байна. БТСГ-т улсын төсвөөс пургон машин олгосон ба аймагт биеийн тамир, спортын ордны барилгын ажлыг 2010 онд эхлүүлэхээр шийдвэрлэгдээд байна.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ

авсралт

йдлаар

хувь

100

90

90

90

90



0

0